

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлд:


“XXXII.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон орон нутгийн худалдан авах ажиллагааны газар, нэгжээс 2017 оны эхний 8 сард зохион байгуулсан худалдан авах ажиллагааны явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ж.Мөнхбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. 2017 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль тогтоомжийн дагуу дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчийг давуу эрхээр шалгаруулж байгааг сайшаан, цаашид дотоодын аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов.

2. Төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.

3. Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулаагүй байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авахыг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэнд даалгав.

4. Салбарын хэмжээнд хэрэгжүүлэх 5 төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтоо Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2017 оны 9 дүгээр сард багтаан хүргүүлж, худалдан авах ажиллагааг эхлүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч Г.Чулуунбаатарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР